ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/169/НА-СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: Gansukh.audit@gmail.com
Аудитор: Р.Цэрэндолгор
Утас: 70323108 Цахим хаяг: Tserendolgorr@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn
Арвайхээр хот
2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3. Аудитын тайлан ..... 10
3.1 Ерөнхий зүйл ..... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Материаллаг байдал ..... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 12
3.8 Аудитын гол асуудал ..... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 13
4. Аудитын илрүүлэлт ..... 13
4.1 Залруулсан алдаа ..... 13
4.2 Төлбөрийн акт ..... 13
4.3 Албан шаардлага ..... 13
4.4 Зөвлөмж ..... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 13

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.22 № 202
танай ______-ны №______-т

УЯНГА СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.ТУУЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

015030403

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Данс | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I) | 59,396,854.28 | 86,801,415.13 |
| 33 | АВЛАГА | 5,090,710.30 | 1,397,039.46 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,090,710.30 | 1,397,039.46 |
| 33101 | Цалингийн авлага | 389,865.00 | - |
| 33102 | НДШ-ийн авлага | 4,691,236.30 | 1,397,039.46 |
| 33103 | ХАОАТ-ын авлага | 9,609.00 | - |
| 34 | УРЬДЧИЛГАА | 9,250,000.00 | - |
| 34700 | Бусад урьдчилгаа | 9,250,000.00 | - |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | 9,250,000.00 | - |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 9,250,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 45,056,143.98 | 85,404,375.67 |
| 35400 | Хангамжийн материал | 45,056,143.98 | 85,404,375.67 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 398,500.00 | 390,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,485,000.00 | 1,188,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 70,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 1,141,850.00 | 4,548,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал<br>Бусад хангамжийн материал | 41,960,793.98 | 79,277,775.67 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II) | 2,276,832,178.86 | 2,198,429,950.86 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,276,832,178.86 | 2,198,429,950.86 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,148,560,012.09 | 2,070,311,784.05 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,994,114,799.57 | 2,005,114,799.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | - 54,552,216.95 | - 128,435,846.76 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 39,625,000.00 | 39,625,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | - 16,666,666.77 | - 23,270,833.28 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 171,263,142.23 | 191,186,442.23 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | - 120,618,783.62 | - 121,316,916.60 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 159,352,802.48 | 169,521,092.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | - 64,208,732.85 | - 84,674,931.19 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,101,000.00 | 4,101,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө | - 584,525.00 | - 1,090,250.00 |
| 39217 | Номын фонд | 36,734,193.00 | 19,552,227.60 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 128,272,166.77 | 128,118,166.81 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | - 397,833.23 | - 551,833.19 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 127,900,000.00 | 127,900,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II) | 2,336,229,033.14 | 2,285,231,365.99 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV) | 0.00 | 7,842,172.97 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 7,842,172.97 |
| 41300 | Өглөг | 0.00 | 7,842,172.97 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 7,842,172.97 |
| 41313 | ХАОАТ-ын өглөг | - | 7,842,172.97 |

| | | | |
|---|---|---|---|
| 41360 | Бусад өглөг | 0.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - 0.00 | - 0.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V) | 2,336,229,033.14 | 2,277,389,193.02 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,336,229,033.14 | 2,277,389,193.02 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,318,097,919.20 | 2,318,097,919.20 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | - 98,151,235.92 | - 156,991,076.04 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | - 98,151,235.92 | - 98,151,235.92 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | - 58,839,840.12 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 116,282,349.86 | 116,282,349.86 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V) | 2,336,229,033.14 | 2,285,231,365.99 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,592,171,268.00 | 1,193,933,843.29 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,437,914,118.00 | 101,982,268.29 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 1,437,914,118.00 | 101,982,268.29 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,437,914,118.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,437,914,118.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 62,417,359.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 39,564,908.69 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,154,257,150.00 | 1,091,951,575.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 1,116,257,150.00 | 979,427,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 114,680,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,001,576,250.00 | 979,427,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 38,000,000.00 | 9,443,475.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 38,000,000.00 | 9,443,475.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 103,080,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 103,080,900.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 1,189,629,827.05 | 1,232,948,558.41 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,189,629,827.05 | 1,232,948,558.41 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,092,955,589.02 | 1,182,039,759.60 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 783,085,608.00 | 751,302,425.64 |
| 210101 | Үндсэн цалин | 771,903,082.00 | 537,379,598.64 |
| 210102 | Нэмэгдэл | 11,182,526.00 | 171,494,927.00 |
| 210104 | Урамшуулал | - | 42,427,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 99,126,911.67 | 100,688,969.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 71,567,130.25 | 100,688,969.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,021,787.31 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,573,749.85 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,360,385.84 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,603,858.42 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 75,241,340.00 | 96,042,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,650,600.00 | 9,923,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 67,591,240.00 | 86,119,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 999,500.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,563,614.00 | 20,839,032.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,154,378.00 | 1,440,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,244,400.00 | 2,698,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 467,900.00 | 634,280.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 482,775.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 315,000.00 | 953,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,361,936.00 | 14,630,477.00 |
| 2105 | Нормативт зардал | 32,205,900.00 | 61,189,750.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 369,500.00 | 1,152,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,836,400.00 | 59,630,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 406,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,601,000.00 | 7,108,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,601,000.00 | 7,108,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 794,300.00 | 812,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 794,300.00 | 812,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 773,000.00 | 3,293,915.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 197,000.00 | 3,293,915.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 76,563,915.35 | 140,762,567.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 145,000.00 | 258,600.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,743,010.00 | 7,759,505.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 72,675,905.35 | 132,744,462.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 96,674,238.03 | 50,908,798.81 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 21,939,560.00 | 12,707,948.81 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,939,560.00 | 12,707,948.81 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 58,354,928.03 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 58,354,928.03 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,379,750.00 | 38,200,850.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,579,750.00 | 36,860,850.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,800,000.00 | 1,340,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 64,028,361.40 | 19,825,125.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 1,402,541,440.95 | - 39,014,715.12 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 64,028,361.40 | 19,825,125.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 64,028,361.40 | 19,825,125.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 64,028,361.40 | 19,825,125.00 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V) | 1,338,513,079.55 | - 58,839,840.12 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,318,097,919.20 | 116,282,349.86 | -98,151,235.92 | 2,336,229,033.14 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,318,097,919.20 | 116,282,349.86 | -98,151,235.92 | 2,336,229,033.14 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,318,097,919.20 | 116,282,349.86 | -98,151,235.92 | 2,336,229,033.14 |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,318,097,919.20 | 116,282,349.86 | -98,151,235.92 | 2,336,229,033.14 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,318,097,919.20 | 116,282,349.86 | -98,151,235.92 | 2,336,229,033.14 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -58,839,840.12 | -58,839,840.12 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,318,097,919.20 | 116,282,349.86 | -156,991,076.04 | 2,277,389,193.02 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,154,257,150.00 | 1,091,951,575.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,154,257,150.00 | 1,091,951,575.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 1,116,257,150.00 | 979,427,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 114,680,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,001,576,250.00 | 979,427,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 38,000,000.00 | 9,443,475.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 38,000,000.00 | 9,443,475.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 103,080,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 103,080,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 1,129,128,150.00 | 1,089,451,575.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,129,128,150.00 | 1,089,451,575.00 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,031,734,261.97 | 1,036,597,626.19 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 772,844,462.00 | 741,833,250.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 520,546,039.00 | 524,610,423.00 |
| 210102 | Нэмэгдэл | 191,743,425.00 | 174,794,927.00 |
| 210104 | Урамшуулал | 60,554,998.00 | 42,427,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 108,378,109.97 | 98,620,801.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,589,210.97 | 69,968,930.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,447,199.39 | 7,275,524.94 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,190,606.33 | 5,756,760.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,256,593.28 | 1,409,484.56 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,894,500.00 | 14,210,100.64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 75,241,340.00 | 96,042,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,650,600.00 | 9,597,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 67,591,240.00 | 86,445,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 999,500.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,621,800.00 | 16,326,975.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 740,700.00 | 2,019,275.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,700,000.00 | 2,400,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 615,800.00 | 629,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 669,400.00 | 684,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 481,900.00 | 858,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,414,000.00 | 9,735,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,213,650.00 | 65,096,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 369,500.00 | 1,182,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,978,250.00 | 63,037,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 865,900.00 | 876,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,661,000.00 | 7,038,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | - |
| 210604 | Урсгал засвар | 10,661,000.00 | 7,038,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 794,300.00 | 812,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 794,300.00 | 812,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,227,500.00 | 3,252,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 651,500.00 | 3,252,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,752,100.00 | 7,574,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,794,400.00 | 556,700.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,957,700.00 | 7,018,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 97,393,888.03 | 52,853,948.81 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 21,939,560.00 | 12,707,948.81 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,939,560.00 | 12,707,948.81 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 58,354,928.03 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 58,354,928.03 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,099,400.00 | 40,146,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,299,400.00 | 38,806,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,800,000.00 | 1,340,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II) | 25,129,000.00 | 2,500,000.00 |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 25,129,000.00 | 2,500,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 25,129,000.00 | 2,500,000.00 |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | 25,129,000.00 | 2,500,000.00 |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 25,129,000.00 | 2,500,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V) | - 25,129,000.00 | - 2,500,000.00 |
| 9 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 10 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII) | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII) | - | - |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Тайлан он | | Хувиар |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | |
| **11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | - | - | - |
| 12 | Татварын бус орлого | 1,082,508,100.00 | 1,082,508,100.00 | 100.00 |
| 122 | Тусламж, санхүүжилтийн орлого | 103,080,900.00 | 103,080,900.00 | 100.00 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 103,080,900.00 | 103,080,900.00 | 100.00 |
| 123 | Татаас санхүүжилтийн орлого | 979,427,200.00 | 979,427,200.00 | 100.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 979,427,200.00 | 979,427,200.00 | 100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,082,508,100.00 | 1,082,508,100.00 | 100.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,082,508,100.00 | 1,069,800,151.19 | 98.82 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,042,362,100.00 | 1,029,654,151.19 | 98.78 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 748,146,300.00 | 741,833,250.00 | 99.15 |
| 210101 | Үндсэн цалин | 559,437,900.00 | 542,303,122.00 | 96.93 |
| 210102 | Нэмэгдэл | 146,280,500.00 | 157,102,228.00 | 107.39 |
| 210104 | Урамшуулал | 42,427,900.00 | 42,427,900.00 | 100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 105,015,700.00 | 98,620,801.19 | 93.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,200,800.00 | 69,968,930.98 | 88.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,453,700.00 | 7,275,524.94 | 112.73 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,163,000.00 | 5,756,760.07 | 111.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,290,700.00 | 1,409,484.56 | 109.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,907,500.00 | 14,210,100.64 | 110.09 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 96,042,800.00 | 96,042,800.00 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,597,600.00 | 9,597,600.00 | 100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 86,445,200.00 | 86,445,200.00 | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,499,900.00 | 13,499,900.00 | 99.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 757,400.00 | 757,400.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,700,000.00 | 1,700,000.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 629,700.00 | 629,700.00 | 100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 684,400.00 | 684,400.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 492,800.00 | 492,800.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,235,600.00 | 9,235,600.00 | 100.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 64,866,200.00 | 64,866,200.00 | 99.99 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 952,100.00 | 952,100.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 63,037,200.00 | 63,037,200.00 | 99.99 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 876,900.00 | 876,900.00 | 100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,538,100.00 | 9,538,100.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 2,500,000.00 | 2,500,000.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,038,100.00 | 7,038,100.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 812,200.00 | 812,200.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 812,200.00 | 812,200.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж | 866,200.00 | 866,200.00 | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 866,200.00 | 866,200.00 | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,574,700.00 | 3,574,700.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 556,700.00 | 556,700.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,018,000.00 | 3,018,000.00 | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 40,146,000.00 | 40,146,000.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 40,146,000.00 | 40,146,000.00 | 100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 38,806,000.00 | 38,806,000.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,340,000.00 | 1,340,000.00 | 100.00 |
| **12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.00 | 9,443,475.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.00 | 9,443,475.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 9,443,475.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0.00 | 2,827,075.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 1,261,875.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 700,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 365,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 500,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 0.00 | 230,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 230,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 0.00 | 2,386,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,386,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 4,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 4,000,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 9,443,475.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 9,443,475.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 9,443,475.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Уянга сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.21-ны өдрийн 11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 "Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино" гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус газар нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газаргүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1,232.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 12.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө өмнөх оноос 71.6 сая төгрөгөөр өссөн нь 16.0 сая төгрөгөөр барилга байгууламж, орон сууц, 37.8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 15.2 сая төгрөгийн тавилга эд хогшил, 2.6 сая төгрөгийн ном нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Бараа материал өмнөх оноос 40.3 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, БСУГ-т нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 1,082.5 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 1,082.5 сая төгрөгөөр батлагджээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв Улсын төсвөөс санхүүжих орлогоос 979.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 103.0 сая төгрөгөөр нийт 1,082.5 сая санхүүжигдэн, 1,082.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн орлого 9.4 сая төгрөгийг санхүүжүүлэн бараа үйлчилгээний бусад зардалд 4.0 сая төгрөг, хангамж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардалд 2.4 сая төгрөг, нормативт зардалд 0.2 сая төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 2.8 нийт 9.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Уянга сумын ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 135 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой

байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын засгийн газрын тогтоол 388-ыг баримтлан ажиллах.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Байхгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Уянга сумын ерөнхий боловсролын сургууль | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 00 | 1 | 00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Р.ЦЭРЭНДОЛГОР

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР